



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Хүүхдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх нийтлэг шаардлага

MNS 7065:2025



Стандарт, хэмжил зүйн газар
Улаанбаатар хот
2025 он



Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар Ш/Х – 48

Утас: 51-263860 11-455284

web: www.estandard.gov.mn,

E-mail: standardinform@masm.gov.mn

© СХЗГ, 2025

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

Агуулга	Хуудас
Өмнөх үг	iv
1. Зорилго	1
2. Хамрах хүрээ	1
3. Норматив эшлэл	1
4. Нэр томъёо, тодорхойлолт	1
5. Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний төрөл	3
6. Сэтгэл зүйн тусламж үйлчилгээний хэлбэр	3
7. Байгууллагад тавих шаардлага	4
8. Сэтгэл зүйн тусламж үйлчилгээний үе шат	6
9. Хориглох зүйл	8
10. А хавсралт. (норматив) Өөрийн хүсэлтээр сэтгэл зүйн тусламж үйлчилгээ авах тухай зөвшөөрлийн хуудас	9
11. В хавсралт (норматив) Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх тухай мэдээлэл өгөх хуудас	10
12. С хавсралт (норматив) Үйлчлүүлэгчийг илгээх хуудас	11
13. D хавсралт(мэдээллийн) Үнэлгээнд мэдээлэл цуглуулах НЕЕЕАDDSS аргачлал	12
14. E хавсралт (мэдээллийн) Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд илрэх шинжүүд ба зан үйл, сэтгэцийн эмгэгүүд	13
15. F хавсралт (мэдээллийн) Зөвлөгөө заслын үйл ажиллагааг хөтлөн явуулах GATHER-ийн аргачлал	14
16. G хавсралт (мэдээллийн) Хүүхэд, өсвөр үеийнхнийг үнэлэх хурдавчилсан асуумжууд	15
17. H хавсралт (норматив) Амиа хорлох оролдлогыг илрүүлэх богино хэмжээний сорил	20
18. Ном зүй	21

Өмнөх үг

Стандарт, хэмжил зүйн газар нь Олон Улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд Улсын стандартчиллын бодлогыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

Тус газар нь тухайн салбарын үндэсний стандартын төсөл боловсруулах ажлыг техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Техникийн хорооны хэлэлцэж, зөвшилцсөн стандартын төслийг Стандартчиллын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэ стандартыг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.9 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах зорилгоор Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сан, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүн амын сан зэрэг олон улсын байгууллагаас боловсруулсан хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлэх дэмжлэг, туслалцаа, үйлчилгээний удирдамж заавар болон Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай ба Хүүхэд хамгааллын тухай хууль, тэдгээрийг дагалдан гарсан дүрэм, журам, зааварт нийцүүлэн боловсруулсан.

Энэ стандартыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга Д.Одончимэг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын хэрэгжилтийг зохицуулах газрын Хүүхдийн эрхийн хууль тогтоомж, бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч Ж.Азжаргал, Монгол Улсын Боловсролын их сургууль, Боловсрол судлалын сургуулийн Нийгмийн ажил арга зүйн тэнхимийн ахлах багш Т.Булганзаяа, зөвлөх, судлаач Ц.Бурмаа нар боловсруулсан.

Энэ стандартыг Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэж зөвшилцсөн болно.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.080.99

Хүүхдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх нийтлэг шаардлага	СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
General requirements for child psychological care and service	СТАНДАРТЫН БОЛОВСРУУЛАГЧИД ОЛГОСОН ХУВЬ

MNS 7065:2025

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн С/06 дугаар тушаалаар батлав.

Энэ стандартыг 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

Зорилго

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд тавих шаардлагыг тогтооно.

1 Хамрах хүрээ

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд (цаашид үйлчлүүлэгч гэх)-д сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон төрийн бус байгууллагын сэтгэл зүйч, сэтгэл засалч, эмнэл зүйн сэтгэл зүйч, сэтгэцийн эмч, нийгмийн ажилтан үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

2 Норматив эшлэл

Энэ стандартын үзэл санаа нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол улсын хэмжээнд баримталж буй дараах бодлогын баримт бичигт суурилсан бөгөөд эдгээрийг нэгэн адил дагаж мөрдөнө. Үүнд:

MNS 6949:2021, Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага

MNS 6040:2019, Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

MNS 6418:2013, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

MNS 5852:2017, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

MNS 5935:2008, Өөрийгөө сургах дасгал

MNS 5936:2008, Харилцан нөлөөлөх бүлгийн сэтгэл засал

MNS 5938:2008, Хүүхдийн зан үйлийн эмгэгийн оношилгоо, эмчилгээ

MNS 4628:2008, Сэтгэцийн эмгэгийн үе дэх оношилгоо, эмчилгээний үйлдэл, стресс оношилгоо, тайлах арга технологи, биеийн өвчиндөө хандах "сэтгэл түгших хариу үйлдэл" бүхий үйлчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээ

MNS 6121:2010, Дасан зохицохуйн эмгэгийн оношилгоо, эмчилгээ

3 Нэр томъёоны тодорхойлолт

Энэ стандартад заасан нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

MNS 7065:2025

3.1

хүүхэд

18 нас хүрээгүй хүн бүр

хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар бүлгийн 8.5-д заасныг,

3.2

эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд

хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 4.1.4-д заасныг буюу "эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд" гэж дараах хүүхдийг ойлгоно.

- a) амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин алдагдсан хүүхэд,
- b) хүчирхийлэлд өртсөн, эсхүл өртөх нөхцөлд байгаа хүүхэд,
- c) эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй хүүхэд,
- d) гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдалд байгаа хүүхэд.

3.3

үйлчлүүлэгч

эрсдэлт нөхцөл байдлын улмаас сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ авч буй хүүхэд

3.4

сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ

сэтгэл зүйн үнэлгээ, сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, зөвлөгөө, сэтгэл засал эмчилгээ

3.5

сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал

нийгэм, сэтгэл зүйн шалтгааны улмаас хүний сэтгэхүй, сэтгэл хөдлөл, зан үйл түр хямарсан байдал

3.6

сэтгэцийн эмгэг

өвчний олон улсын 10-р ангиллын "сэтгэц, зан үйлийн эмгэгүүд" бүлэгт заасан оношилгооны хэмжүүрээр оношилж болох бүх өвчин

3.7

сэтгэл зүйн тусламж үзүүлэх мэргэжилтэн

сэтгэл зүйч, сэтгэл засалч, эмнэл зүйн сэтгэл зүйч, сэтгэцийн эмч, нийгмийн ажилтан

3.8

сэтгэцийн эмч

сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.1.16-д заасныг буюу "сэтгэцийн эмч" гэж анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль төгссөн, сэтгэцийн эмчийн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг дүүргэж, эмчлэх эрхийн зөвшөөрөл авсан хүний их эмч

3.9

сэтгэл засалч

сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.1.18-д заасныг буюу "сэтгэл засалч" гэж сэтгэл заслаар төрөлжсөн мэргэшил эзэмшсэн сэтгэцийн эмч

3.10

сэтгэл зүйч

сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.1.17-д заасныг буюу "сэтгэл зүйч" гэж их, дээд сургуулийг сэтгэл зүйн мэргэжлээр төгссөн мэргэжилтэн

3.11

эмнэл зүйн сэтгэл зүйч

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.1.19-д заасныг буюу "эмнэл зүйн сэтгэл зүйч" гэж эмнэл зүйн сэтгэл зүйгээр төрөлжсөн мэргэшил эзэмшсэн сэтгэцийн эмч

3.12

нийгмийн ажилтан

баг, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажлын үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтан

ТАЙЛБАР: Нийгмийн ажилтан нь хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийтэд тулгарч буй асуудалд чиглэн үйлчлүүлэгчтэй тулж ажиллах, үйлчлүүлэгчийн амьдарч буй орчны тогтолцоонд нийгмийн үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулах зэргээр нийгмийн бодлого төлөвлөлт, зохицуулалтад нөлөөлөх, судалгаа үнэлгээ хийх чиглэлээр ажиллана.

4 Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний төрөл

4.1 Сэтгэл зүйн байдлын үнэлгээ

Үнэлгээг асуумжийн арга, ажиглалт, олон улсад зөвшөөрөгдсөн түргэвчилсэн сорил ашиглан сэтгэл зүйч, сэтгэл засалч, эмнэл зүйн сэтгэл зүйч, сэтгэцийн эмч, нийгмийн ажилтан хийнэ.

4.2 Анхан шатны сэтгэл зүйн зөвлөгөө (Сэтгэл зүйн болон сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл зөвлөгөө, тайвшруулах амьсгалын дасгал гэх мэт)-г сэтгэл зүйч, сэтгэл засалч, эмнэл зүйн сэтгэл зүйч, сэтгэцийн эмч, нийгмийн ажилтан өгнө.

4.3 Ахисан шатны сэтгэл зүйн зөвлөгөө (Тулгамдсан асуудалд чиглэсэн аргачлал,техникүүд ашиглан ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр)-г сэтгэл зүйч, сэтгэл засалч, эмнэл зүйн сэтгэл зүйч, сэтгэцийн эмч, нийгмийн ажилтан өгнө.

4.4 Сэтгэл засал эмчилгээ (Ганцаарчилсан болон бүлгийн сэтгэл засал)-г сэтгэл засалч, эмнэл зүйн сэтгэл зүйч хийнэ.

4.5 Эмийн эмчилгээ (Зөвхөн эмчийн заалтаар)

5 Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний хэлбэр

5.1 Биечлэн уулзалт хийх

Үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн байдлын үнэлгээ, анхан шатны болон ахисан шатны сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл засал эмчилгээ болон эмийн эмчилгээг сэтгэл зүйн тусламж үзүүлэх мэргэжилтэн биечлэн хийнэ.

5.2 Утсаар

Зөвхөн анхан шатны сэтгэл зүйн зөвлөгөө/мэдээллийг утсаар өгч болно. Утсаар зөвлөгөө мэдээлэл өгөхдөө дараах зүйлсийг анхаарна. Үүнд: Нэг дор олон асуулт

MNS 7065:2025

тавихгүй байх, өөрийн санаа бодлыг тулгахгүй байх, үйлчлүүлэгчийг өөрийг нь буруутгасан үг хэллэг хэлэхгүй байх.

5.3 Цахим хэлбэрээр

Сэтгэл зүйн байдлын үнэлгээ болон анхан шатны сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ мэдээлэл өгнө. Цахимаар удаа дараа холбогдсон үйлчлүүлэгчтэй биечлэн уулзалт хийх, амиа хорлох эрсдэл болон бусад эрсдэлтэй шинж тэмдгүүд илэрвэл мэргэжлийн байгууллагын үйлчилгээг санал болгох, нэн даруй холбон зуучлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

6 Тавих шаардлага

6.1 Байгууллагад тавих шаардлага

6.1.1 Байгууллага нь оноосон нэр, улсын бүртгэлийн гэрчилгээтэй байна.

6.1.2 Төрийн бус байгууллага, холбоо нь төрийн эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн байна.

6.1.3 Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой тушаал, журам, хэрэглэх маягыг байгууллагын захирал/даргаар батлуулан мөрдөн ажиллана.

6.1.4 Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнийг бие даасан орон тоогоор ажиллуулна.

6.1.5 Байгууллага нь сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэжилтний мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, практик туршлагыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хүний нөөцийн бодлоготой байна.

6.1.6 Мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар тодорхой журам, заавар, удирдамж хэрэгжүүлнэ.

6.1.7 Байгууллагын үйлчлүүлэгчийн талаарх мэдээлэлтэй харьцах ажилтнуудын эрх, үүргийг тодорхой зохицуулна.

6.1.8 Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн ажилд авахдаа ажил горилогчоос өмнө нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл болон хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж, эрүүгийн шийтгэл хүлээсэн эсэх лавлагаа шаардана.

6.1.9 Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд зориулсан, тусгайлан бэлдсэн ганцаарчилсан болон бүлгийн өрөө, хүлээлгийн хэсэгтэй байна. Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг үзүүлэх өрөөг хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт нь тохирсон, хүүхдэд тав тухтай уур амьсгалыг бүрдүүлсэн, зөөлөн буйдан, сандал, сэтгүүлийн ширээ, цаасан салфетка, сэтгэл зүйн тусламж, үйлчилгээнд ашиглах тоглоом, төхөөрөмж, хэрэглэгдэхүүнтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан нөхцөл бүрдүүлэн тохижуулна. Өрөө нь гаднын дуу чимээнээс бүрэн тусгаарлагдсан, дуудлагын хонхтой, хангалттай гэрэлтүүлэгтэй, өрөөний дотор хананы ерөнхий дэвсгэр өнгө нь тод биш, шар, хөх, ногоон өнгийн сүүдэр, элементийг оруулна. Өрөө нь цонхтой, цонх нь зузаан хөшигтэй, хангалттай гэрэлтүүлэгтэй, агааржуулалттай, дулаан байна.

6.1.10 Үйлчлүүлэгчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангана. Мэдээллийг хадгалах техник, хэрэгсэл, сорилыг цаасаар болон цахимаар хийх нөхцөл бүрдүүлнэ. (Цаасан материалыг цоожтой шүүгээнд хадгалах, цахим мэдээллийг компьютерт хадгалахдаа нууц код, дугаар хийх)

7 Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэнд тавих шаардлага

7.1 Мэргэжлээрээ бакалавр болон түүнээс дээш зэргийн боловсрол эзэмшсэн.

7.1.1 Сэтгэл зүйн тусламж үзүүлэх чиглэлээр ажиллаж байсан дадлага туршлагатай.

7.1.2 Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үүссэн сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг үнэлэх, оношлох, зөвлөгөө, заслын үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэн ажиллах чадвартай.

7.1.3 Хүүхдийн эрхэд суурилсан хандлагатай.

7.1.4 Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтэн нь холбогдох хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмын талаар мэдлэгтэй, түүнийг хэрэгжүүлэх чадвартай.

7.1.5 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй бол онцлог үйлчилгээ шаардана гэдгийг анхаарч үзнэ.

7.1.6 Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтэн нь мөрдөгдөж буй эрх зүй, ёс зүйн баримт бичгүүдийн заалтыг чанад баримтлан ажиллана.

7.1.7 Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтэн нь тусламж үйлчилгээ үзүүлэх явцдаа хүүхэд болон түүний гэр бүл, асран хамгаалагчтай хүндэтгэлтэй хандах, хүнлэг, энэрэнгүй байх, чин үнэнч, шударга байх, хүн бүрд тэгш хандах, үл ялгаварлах, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

7.1.8 Нууцыг чандлан хадгална.

7.1.9 Тусламж, үйлчилгээг хөндлөнгийн саадгүй орчинд үзүүлнэ.

7.1.10 Үйлчлүүлэгчид хүчирхийллийн (бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны, үл хайхрах гэх мэт) шинж тэмдэг байгаа эсэхийг байнга анхаарч, илэрсэн тохиолдолд холбогдох байгууллагад мэдээлж, давтагдахаас урьдчилан сэргийлж ажиллана.

7.1.11 Тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгчийн мэдээлэлд тавих шаардлагын дагуу тухай бүрд холбогдох маягтыг хөтлөн, үзүүлж буй тусламж, үйлчилгээ, сорилыг цаас эсхүл цахим хэлбэрээр тэмдэглэж, баримтжуулан, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах мэдлэг, чадвартай байна.

7.1.12 Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтэн нь мэргэжлийн болон салбар дундын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, зөвшилцөх мэдлэг, чадвартай байна.

7.2 Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээнд тавих шаардлага

7.2.1 Үйлчлүүлэгчтэй хүндэтгэлтэй хандана.

MNS 7065:2025

7.2.2 Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг ханган тусламж үзүүлнэ.

7.2.3 Үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцлалыг хангана. (Хүүхэд болон гэр бүлийн мэдээллийн нууц)

7.2.4 Үйлчлүүлэгчийг үл ялгаварлана.

7.2.5 Үйлчлүүлэгчийн үнэт зүйлийг нь хүндэтгэж, сэтгэцийн байдал болон бодол мэдрэмжүүдийг ойлгож, сэтгэл хөдлөлийг нь мэдэрч, хүүхдийн үгийг аль болох таслахгүй, анхааралтай сонсож харилцана.

7.2.6 Үйлчлүүлэгч хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн сэтгэл зүйн тулгамдаж буй асуудал, мэдрэмжээ илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол орчуулагч, хэлмэрч заавал оролцуулна. Орчуулагч, хэлмэрчид урьдчилан мэдээлэл өгч, чиглүүлнэ. Орчуулагч, хэлмэрч нь үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцыг чандлан хадгална.

7.2.7 Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлог, хэл ярианы хөгжилд тохирсон асуулт тавих Шаардлагатай үед үйлчлүүлэгчийг нөхөн сэргээх болон бусад тусламж, үйлчилгээнд холбон зуучлах журмын дагуу аюулгүй, мэдээллийн нууцыг хадгалан холбон зуучилна.

8 Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний үе шат

8.1 Бэлтгэх үе

8.1.1 Тусламж үйлчилгээ үзүүлэх орчин бэлдэх (Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ явуулахад зориулагдсан ганцаарчилсан болон бүлгийн бэлтгэгдсэн тусгайлсан өрөө)

8.1.2 Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн хүүхдэд үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээнд ашиглах өнгийн харандаа, цаас, зөөлөн тоглоом, цаасан уут, сэтгэл зүйн үнэлгээний сорилын хуудас, стресс тайлагч зөөлөн бөмбөлөг, салфетка зэрэг хэрэглэгдэхүүнийг бэлдэнэ.

8.1.3 Мэргэжилтэн өөрийгөө бэлдэх (Өмнөх үйлчлүүлэгчийн уулзалтаас завсарлага авах, үйлчлүүлэгчийн талаарх объектив мэдээлэлтэй танилцах, давтан уулзалт бол өмнөх уулзалтын үеийн мэдээлэлтэй эргэн танилцах г.м)

8.2 Сэтгэл зүйн холбоо тогтоох, үнэлгээ хийх үе

8.2.1 Анхны уулзалт, үнэлгээ хийх үе - Хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс таниулсан зөвшөөрлийн хуудсаар (А хавсралт) зөвшөөрөл авна. Сэтгэл зүйн тусламж үйлчилгээнээс үйлчлүүлэгч болон эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч татгалзах тохиолдол гарсан үед тусламж үйлчилгээг зайлшгүй авах шаардлага, хэрэгцээ, ач холбогдлын талаар мэдээллийг өгч, сайтар ойлгуулж Сэтгэл зүйн тусламж үзүүлэх тухай мэдээлэл өгөх хуудсаар (В хавсралт) баталгаажуулан сэтгэл зүйн тусламж үйлчилгээг үзүүлнэ. Үнэлгээнд мэдээлэл цуглуулахдаа (D хавсралт) НЕЕЕАДДС аргачлалыг ашиглана. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд илрэх шинжүүд ба зан үйлийг (Е хавсралт) асуумж, ажиглалт, түргэвчилсэн сорилоор үнэлэн тохирох тусламж үйлчилгээ үзүүлэх бөгөөд эрсдэлтэй шинжүүд байвал дараагийн тусламж үйлчилгээнд илгээнэ.

8.2.2 Үйлчлүүлэгчийн сэтгэцийн эрүүл мэндийн байдалд дараах нөхцөл байдал тогтоогдвол нэн даруй сэтгэцийн мэргэжлийн эмчид үйлчлүүлэгчийг илгээх хуудас (С хавсралт)-аар илгээнэ.

8.2.2.1 Амиа хорлох эрсдэлтэй - Өмнө нь амиа хорлох оролдлого хийж байсан, удамд нь амиа хорлох оролдлого хийж байсан өгүүлэмжтэй, амиа хорлох эрсдэлийг (Н хавсралт) үнэлэх сорилоор эрсдэлтэй гэж үнэлэгдсэн

8.2.2.2 Нийгэмд болон өөртөө аюултай үйлдэл хийх эрсдэл бүхий сэтгэцийн байдал (Асуумж болон гаргаж буй төрх үйлийг ажиглаж үнэлнэ)

8.2.2.3 Цаг хугацаа, орон зай, өөрийн баримжаа буурсан буюу алдагдсан байх (нүүр тулсан ярилцлага, ажиглалтаар үнэлнэ)

8.2.2.4 Сэтгэцийн бусад эмгэг (Солиорлын шинж тэмдэг, сэтгэл гутралын хүнд хэлбэр гэх мэт бусад).

8.3 Сэтгэл зүйн тусламж үйлчилгээний төлөвлөгөө гаргах

Үнэлгээний үр дүнд тулгуурлан хүүхдэд тохирсон сэтгэл зүйн зөвлөгөө, заслын арга техникийг сонгоно. Төлөвлөгөөнд тусламж, үйлчилгээний үргэлжлэх хугацаа, давтан уулзалтын цаг товлох, ямар арга техникээр ажиллах, зөвлөгөө тусламжийн хэлбэрийг тусгасан байна. Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний төлөвлөгөө гаргахдаа шаардлагатай үед хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг оролцуулна.

8.4 Тусламж, үйлчилгээ үзүүлэх үе

8.4.1 Сэтгэл зүйн тусламж үйлчилгээг үзүүлэхдээ үйлчлүүлэгчийн насны онцлог, илэрч буй шинж тэмдэг ба зан үйл, сэтгэцийн эмгэгийн шинж (Е хавсралт) болон хувийн онцлогийг харгалзан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалыг сонгон ганцаарчилсан болон бүлгээр зохион байгуулна.

8.4.2 Зөвлөгөө, заслын үйл ажиллагааг хөтлөн явуулахдаа (F хавсралт) GATHER-ийн аргачлалыг ашиглана.

8.4.3 Анхны уулзалтын үргэлжлэх хугацааг 120 минутаас хэтрэхгүй байхаар, давтан уулзалтыг 90 хүртэлх минутаар хийнэ.

8.4.4 Бүлгийн сэтгэл зүйн тусламж үйлчилгээнд (Харилцан нөлөөлөх бүлгийн сэтгэл засал, дэмжих бүлгийн хөтөлбөр гэх мэт) ашиглах бөгөөд 8-аас доошгүй удаа хамруулсан байна.

8.5 Эргэн үнэлгээ хийх үе - Тусламж үйлчилгээний зорилгод хүрсэн эсэхийг үнэлэх

8.5.1 Үйлчлүүлэгчид үзүүлсэн сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг түргэвчилсэн сорил, аргачлал, ажиглалтын аргааг үнэлсэн байна.

8.5.2 Сэтгэл зүйн тусламж үйлчилгээний төлөвлөгөөнд тусгасан зорилго, зорилтууд биелэгдсэн байдал, өөрчлөлт хийх шаардлагатай эсэхийг үнэлнэ.

MNS 7065:2025

8.5.3 Тусламж, үйлчилгээний үр дүнг үнэлэхэд үйлчлүүлэгч, түүний гэр бүлийг оролцуулна.

8.6 Тусламж, үйлчилгээг хаах, зогсоох үе

Эргэн үнэлгээгээр тусламж үйлчилгээний төлөвлөгөөнд тусгасан зорилгодоо хүрсэн бол сэтгэл зүйн тусламж үйлчилгээг зогсооно.

9 Хориглох зүйл

9.1 Үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцлалыг хангахгүй байх,

9.2 Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтэн тусламж үйлчилгээ үзүүлэх үйл явцад саад болохуйц өөрийн сэтгэл хөдлөлийн асуудлыг шийдвэрлээгүй тохиолдолд үйлчлүүлэгчтэй харилцах,

9.3 Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтэн үйлчлүүлэгчид албадсан, тулгасан асуулт тавьж болохгүй,

9.4 Үйлчлүүлэгчид хор хохирол учруулахуйц, үр дүнгүй арга техник ашиглах,

9.5 Үйлчлүүлэгчийн бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэл зүйн тусламж үйлчилгээтэй холбоотой бичиг, баримтыг хуурамчаар үйлдэх эсвэл хуурамч бичиг баримтад гарын үсэг зурах, устгах зэрэг үйлдэл гаргах,

9.6 Өөрийнхөө бодол санааг үйлчлүүлэгчид тулган хүлээлгэх,

9.7 Үйлчлүүлэгчийн хувийн онцлог, ялгаатай байдлыг харгалзан үзэхгүй, ялгаварлан гадуурхах,

9.8 Үйлчлүүлэгч хэн нэгний бие махбодод гэмтэл учруулахаар төлөвлөж буйг мэдсэн боловч урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахгүй байх,

9.9 Үйлчлүүлэгч өөрийгөө гэмтээхээр төлөвлөж буйг мэдсэн боловч шаардлагатай арга хэмжээ авахгүй байх,

9.10 Үйлчлүүлэгчид шаардлагатай сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзах,

9.11 Үйлчлүүлэгчийг бусад шаардлагатай үйлчилгээнд холбохгүй, хамруулахгүй байх,

9.12 Үйлчлүүлэгчтэй дотно харилцаа тогтоох,

9.13 Үйлчлүүлэгчээс бэлэг, сэлт хүлээн авах,

ТӨГСӨВ.

А хавсралт
(норматив)

**Өөрийн хүсэлтээр сэтгэл зүйн тусламж үйлчилгээ авах
тухай зөвшөөрлийн хуудас**

(Үйлчлүүлэгч болон асран хамгаалагчаас авах)

Үйлчлүүлэгч _____ овогтой _____ би сэтгэл зүйн
тусламж үйлчилгээ авах хүсэлтэй байна.

Миний зүгээс Сэтгэл зүйн тусламж үйлчилгээг авах гэж буй шалтгаан:

.....
.....
.....

Үйлчлүүлэгчийн гарын үсэг /...../
/Нэр/

Үйлчлүүлэгч гарын үсэг зурах боломжгүй бол:

Эцэг эх, асран хамгаалагч /харгалзан дэмжигч/-ийн гарын үсэг
..... /...../
/Нэр/

Энэхүү зөвшөөрлийн хуудасны загварыг 2 хувь үйлдсэн болно.

..... он сар өдөр

В хавсралт
(норматив)

**Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх тухай
мэдээлэл өгөх хуудас**

Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх шаардлага, үндэслэл:
(Сэтгэл зүйн тусламж үзүүлэх мэргэжилтэн ямар тусламж, үйлчилгээ үзүүлэх саналтай байгаа тухай товч бичнэ)

.....
.....
.....
.....

Үйлчлүүлэгч _____ овогтой _____ би сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг авах тухай мэдээлэлтэй танилцсан болно.

Үйлчлүүлэгчийн гарын үсэг /...../
/Нэр/

Үйлчлүүлэгч гарын үсэг зурах боломжгүй бол:

Эцэг эх, асран хамгаалагч /харгалзан дэмжигч/-ийн гарын үсэг
..... /...../
/Нэр/

Энэхүү мэдээлэл өгөх хуудсыг 2 хувь үйлдсэн болно.

..... он сар өдөр

С хавсралт
(норматив)

Үйлчлүүлэгчийг илгээх хуудас

Хаягийн хэсэг

Овог нэр Нас РД

Хүйс (сонгох) 1. эрэгтэй 2. Эмэгтэй

Утасны дугаар

Эцэг эх, асран хамгаалагч /харгалзан дэмжигч/-ийн утасны дугаар

Гэрийн хаяг:.....

“Илгээх” хэсэг

Илгээж буй байгууллагын нэр

Илгээсэн он ... сар..... өдөр..... цаг..... минут

Тусламж үйлчилгээ үзүүлсэн мэргэжилтний овог, нэр

Үйлчлүүлэгчийн хувийн дугаар

Хүлээн авч буй байгууллагын нэр.....

Үйлчлүүлэгчийг илгээж байгаа шалтгаан (сонгох)

Сэтгэцийн эмчийн үзлэг оношилгоо, эмчилгээ

Аюулгүй байдлыг хангах

Бусад: /тодорхой бичих/.....

Сэтгэл зүйн болон сэтгэцийн байдлын үнэлгээ, шинж тэмдэг /дэлгэрэнгүй бичих/

.....

.....

.....

Илгээсэн мэргэжилтний нэр утасны дугаар

цахим хаяг.....

Илгээсэн байгууллагад өгөх зөвлөмж /бичих/

.....

.....

Тэмдэглэх нь: Хүлээн авсан байгууллага нь тусламж үйлчилгээ дууссан даруйд үйлчлүүлэгчийг илгээсэн байгууллагад эргэн мэдээлнэ.

.....он.....сар.....өдөр
.....цаг.....минут.

D хавсралт
(мэдээллийн)

Үнэлгээнд мэдээлэл цуглуулах HEEEADDSS аргачлал

Home/Гэр бүл	Гэр бүл, эцэг эх, гэрийн дотоод харилцаа, уур амьсгалын талаарх мэдээлэл
Education/Боловсрол	Боловсрол, сургуультай холбоотой мэдээлэл
Employment/Ажил	Ажил мэргэжил Хэрэв ажилладаг бол ажлынх нь талаарх мэдээлэл
Eating/Хооллолт	Хооллолт, хооллох дурын талаарх мэдээлэл
Activities/үйл ажиллагаа	Ямар үйл ажиллагаанд оролцдог, чөлөөт цагаа хэнтэй, хэрхэн өнгөрүүлдэг гэх мэт
Drugs/Мансуурах бодисын хэрэглээ	Мансууруулах эм бодисын хэрэглээтэй холбоотой мэдээлэл
Depression/Сэтгэл гутрал	Сэтгэл санааны байдал, сэтгэл зовоосон асуудлуудын талаарх мэдээлэл
Sexuality/Бэлгийн бойжилт	Бэлгийн бойжилт, бэлгийн амьдралтай холбоотой мэдээлэл
Suicide/Амиа хорлох эрсдэл	Амиа хорлох эрсдэл бий эсэхийг тодруулна
Safety/Аюулгүй байдал	Аюулгүй орчин нөхцөлийн талаарх мэдээлэл (хүчирхийлэлтэй орчинд амьдардаг эсэх

Е хавсралт
(мэдээллийн)

**Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд илрэх шинжүүд ба
зан үйл, сэтгэцийн эмгэгүүд**

Сэтгэл зүйн шинж тэмдэг	Бие махбодын шинж	Илрэх зан үйл	Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэг
<ul style="list-style-type: none"> -Олон дахин санаа алдах -Өөрийгөө буруутгах -Өөрийгөө бусдаас доогуур үнэлэх -Байнгын айдас түгшүүртэй байх - Хий юм сонсох, харах - Зүүдэндээ цочиж сэрэх - Уйлах - Сандарч тэвдэх - Ой тогтоолт муудах -Сурлагаар хоцрох сурлагадаа муудах, хичээлдээ дургүй болох -Уур бухимдлаа барьж чадахгүй байх -Эцэг эх, асран хамгаалагч нь орхиод явахаас айх -Эцэг эхийнхээ хэнийг нь сонгохоо мэдэхгүй эргэлзэх - Болсон зүйлээс ичих -Тусгаарлагдаж орхигдсон мэт мэдрэх -Анхаарал халамж шаардах -Сахилгагүй, дүрсгүй болох -Ганцаардах, өөрийгөө тусгаарлах -Архи, мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэх -Асран хамгаалагч, эцэг эх, найз нөхөд, багш нарынхаа үгэнд орохгүй, дүрсгүйтэх -Гэмтлийн дараах стресс эмгэгийн шинж тэмдэг илрэх -Сэтгэлээр амархан унах -Стрессийн шинж тэмдэг илрэх -Дасан зохицох чадвар буурах 	<ul style="list-style-type: none"> -Нойргүйдэх -Хэт их нойртой болох -Хоолны дуршил буурах -Хоолны дуршил ихсэх - Зүрх дэлсэх - Гар салгалах - Булчин чангарах - Булчин сулрах - Толгой өвдөх - Ходоод өвдөх -Шээс ойрхон хүрэх -Гэдэс базалж өвдөх -Биеийн энд тэнд өвдөлт илрэх -Бага насны хүүхэд жингийн дутагдалтай байх -Бусад хүүхэдтэй харьцуулахад өсөлт хөгжлийн хувьд сааталтай эсвэл хоцрогдолтой (жижиг, намхан) 	<ul style="list-style-type: none"> -Хүчирхийлэгчтэй ноцолдох, орилж хашхирах, бүх чадлаараа тэмцэлдэх, эсэргүүцэх (Тулалдах Fight) -Гэмтээгч үйл явдал болсон газраас зугтааж гарах, бусдыг сонсмооргүй байх, санаатай болон санамсаргүйгээр зай барьж, хөндийрөх, хичээлээ таслах (Зугтаах Flight) -Тэмцэлдэх боломжгүй, хүч хүрэхгүй байгаагаа мэдэрч бодит орчноос өөрийгөө “тусгаарлах”, дотроо бол энэ бүхний эсрэг юу ч хийж чадахгүй байгаадаа бухимдах, хэт их эмзэглэх (Хөших Freeze) Өөртөө хариуцлага хүлээхгүй, бусдад (үе тэнгийнхэн, насанд хүрэгчид) найдах, шийдэмгий бус, хүн хүний аяыг харагч, хүчирхэг нэгнийг аялдан дагах хандлагатай (Найр Friend/Fawn) тавих 	<ul style="list-style-type: none"> -Хүүхдийн сэтгэл түгших эмгэг -Сэтгэл түгших эмгэг илэрсэн хүүхэд, эцэг эхэд өгөх мэдээлэл, зөвлөгөө -Сэтгэл зүйн гэмтлийн дараах стрессийн эмгэг -Анхаарал хэт дутмагшил, хэт хөдөлгөөнтөө эмгэг -Хүүхдийн төрх үйлийн эмгэг -Хүүхдийн сэтгэл гутрах эмгэг -Архи, мансууруулах бодис хэрэглэх эмгэг -Гар утас, компьютерт донтох эмгэг -Хооллох дурын эмгэг - Булчин татваганах эмгэг, Тик

F хавсралт
(мэдээллийн)

**Зөвлөгөө заслын үйл ажиллагааг хөтлөн явуулах
GATHER-ийн аргачлал**

Greet/Мэндлэх	Үйлчлүүлэгчтэй дотночлон мэндчилж, өөрийгөө танилцуулна, нэрийг нь асуун танилцах, хүндэтгэлтэй хандах, итгэлийг дааж мэдээллийн нууцлалыг хамгаалахад боломжийн хирээр туслахыг хүсэж байгаагаа хэлэх зэргээр уулзалтыг эхлүүлнэ. – “Би танд/чамд туслахыг хүсэж байна, ...туслахад бэлэн байна...” – “Хэрэв би таны/чиний хэлсэн зүйлийг буруу ойлгосон бол надад хэлээрэй. Би чухам юу болоод өнгөрсөн талаар мэдэхийг хүсэж байна – “Хэрэв та миний хэлэх зүйлийг ойлгохгүй байвал хэлээрэй, би дахин ойлгомжтойгоор хэлэхийг/тайлбарлахыг оролдох болно...””
Ask/Асуух	Зовуурь шаналгаа, санааг нь зовоож буй зүйлс, тулгамдсан асуудлынх нь тухай асууж тодруулах (урьдчилан төлөвлөсөн нээлттэй асуултуудыг асуух, HEEEEADDSSS аргачлалыг ашиглан мэдээлэл олж авах гэх мэт)
Tell/Хэлэх	Одоогоор бие махбод, сэтгэл санаа, зан төрхөд илэрч буй шинж тэмдгүүдийн учир шалтгаан, буруу зөрүү ойлголтыг нь энгийн ойлгомжтой байдлаар тодорхой тайлбарлан, тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэхэд туслах арга зам, шаардлагатай мэдээллийг хэлж өгнө
Help/Туслах	Оновчтой шийдвэр гаргах, зөв арга замыг сонгоход нь туслах (Өөрөө бие даан шийдвэр гаргаж сонголт хийх боломжоор хангана. Өмнөөс нь шийдвэр гаргах, сонголтыг нь үл хүндэтгэх, буруушаах, аль нэг арга замыг сонгохыг тулгахаас зайлсхийх)
Explain/Тайлбарлах	Сонгосон арга замаа хэрэгжүүлэхэд юу хийвэл зохихыг тайлбарлаж өгнө. (Гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэхийн тулд сонгосон арга замынх нь давуу болон сул талуудын тухай тайлбарлан, юуг хэзээ, хэрхэн хийвэл зохистой болох талаар хэлэлцэж, бусдын сайн туршлагын талаарх мэдээллийг хуваалцана)
Return/Эргэх холбоо	Дахин ирэхийг зөвлөх, боломжтой бол дараагийн уулзалтаа товлоно.

G хавсралт
(мэдээллийн)

Хүүхэд, өсвөр үеийнхнийг үнэлэх хурдавчилсан асуумжууд

Сэтгэл зүйн гэмтэл авсан хүүхдийн бие болон сэтгэцийн эрүүл мэндийн шинж тэмдгийн үнэлгээ

Эцэг эхчүүд өөрийн хүүхдэд сүүлийн 7 хоногийн турш ажиглагдаж буй шинж тэмдгийн дагуу үнэлнэ. Зөв, буруу хариулт гэж байхгүй.

G.1 Нярай болон бага нас (0- 3 нас)

1-р хүснэгт

д/д	Сүүлийн 7 хоногт тулгамдаж буй асуудлууд	Үгүй	Тийм
1.	Унтах болон баах нь асуудалтай байна уу?	0	1
2.	Чанга болон хэвийн биш чимээ, доргионд уйлж байна уу?	0	1
3.	Биеэ хураан чангалж, хөдлөхгүй хөшүүн болж байна уу?	0	1
4.	Шалтгаангүйгээр, тэсгэлгүйгээр уйлж байна уу?	0	1
5.	Үг яриа, үйлдэл хөдөлгөөнийг даган дуурайх нь буурсан уу?	0	1
6.	Хамааралтай байна уу, тусдаа байхаас айгаад, аав ээжээсээ салахгүй наалдаад байна уу?	0	1
7.	Хүчирхийлэлтэй төстэй нөхцөл байдалд зугтаах юм уу сэрэмжлүүлэх дүрслэл, үйл хөдлөл хийж байна уу?	0	1
Нийт оноо			

G.1.1 Тайлбар ба үнэлгээний үр дүн: Оноог доош нэмж, нийт оноог гаргана.

Нийт оноо	Авах арга хэмжээ
1-2	Анхаарал тавь, амраа, 7 хоногийн дараа дахин үнэлэх
3-4	Тусламж хэрэгтэй, сэтгэл засалч болон сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага, мэргэжилтнээс тусламж авах
5-7	Яаралтай тусламж хэрэгтэй, сэтгэл засалч болон сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага, мэргэжилтнээс нэн даруй тусламж авах, цаашдын оношилгоо эмчилгээнд шилжүүлэх

G.2 Бага насны болон сургуулийн бага ангийн хүүхэд (3 – 10 нас)

2-р хүснэгт

д/д	Сүүлийн 7 хоногт тулгамдаж буй асуудлууд	Үгүй	Тийм
1.	Хүчирхийллийн үед тохиолдсон сэтгэл зүйн байдлаа гэмтлээ давтах үйлдэл хийх	0	1
2.	Илэрхий айж түгшсэн байдалтай байх	0	1
3.	Хүчирхийллийн дараах тодорхой нэг үйл явдлаас айх	0	1
4.	Хүчирхийлэл дахих вий гэж айх	0	1
5.	Дахин дахин санах (хүчирхийллийн үеийн дүр зураг, мэдрэмжээс гарч чадахгүй байх)	0	1
6.	Хичээл сурлагадаа муудах, анхаарал сарних	0	1
7.	Төрх үйл нь өөрчлөгдөх, буцаж нялхамсах	0	1
8.	Дуугарах, зожгирах, хэвийн биш учир нь олдохгүй аашлах, дуулгаваргүй болох	0	1
9.	Дуртай зүйлдээ дургүйцэх	0	1
10.	Нойрны эмгэг: хар дарах, зүүдэн явах, унтахгүй байх	0	1
11.	Шалтгаангүйгээр өвчин тоочих, зовуурилах	0	1

MNS 7065:2025

12.	Хүчирхийллийн өдрийг (ой) эргэн санах, гоншигнох, тохиромжгүй аяглах	0	1
Нийт оноо			

G.2.1 Тайлбар ба үнэлгээний үр дүн: Оноог доош нэмж , нийт оноог гаргана

Нийт оноо	Авах арга хэмжээ
1-3	Анхаарал тавьж, амраах, 7 хоногийн дараа дахин үнэлэх
4- 6	Тусламж хэрэгтэй, сэтгэл зүйч болон сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага, мэргэжилтнээс тусламж авах
7 -12	Яаралтай тусламж хэрэгтэй, сэтгэл зүйч болон сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага, мэргэжилтнээс нэн даруй тусламж авах, цаашдын оношилгоо эмчилгээнд шилжүүлэх

G.3 Өсвөр үеийнхэн (11 -18 нас)

3-р хүснэгт

д/д	Сүүлийн 7 хоногт тулгамдаж буй асуудлууд	Үгүй	Тийм
1.	Хүчирхийлэлтэй холбоотойгоор хяналтгүй аашилж авирлаж байна уу? Жишээ нь: хүчирхийллийн голомт руу эргэн очиж бусдыг аврах гэж зүтгэх зэрэг аюултай эрсдэлтэй үйл хөдлөл хийх	0	1
2.	Гашуудах, буруутай мэт мэдрэх, ичих гэх мэт сөрөг сэтгэл хөдлөлүүдээ ил гаргахгүй, мэдэгдүүлэхгүй байхыг хичээх	0	1
3.	Дотоод шаналалтайгаа нүүр тулахаас зайлсхийн, зугтах, биеийн хүчний үйл хөдлөл рүү илүү тэмүүлэх	0	1
4.	Осолд өртөмтгий байх	0	1
5.	Нойрны болон хооллохын өөрчлөлт	0	1
6.	Хүчирхийллийг мартаж чадахгүй, байн байн эргэн санаж, ой дурсамжтайгаа зууралдах, уур уцаартай болох	0	1
7.	Сэтгэлээр унах, бусдаас хамааралтай болох, хорвоо ертөнцийг сөргөөр харах	0	1
8.	Зан ааш нь өөрчлөгдөх, эцэг эх, төрөл садантайгаа харьцдаг харилцаа өөрчлөгдөх	0	1
9.	Хүчирхийллийн тухай дурсамжаасаа ангижрахын тулд насанд хүрсэн том хүн шиг байхаар яарах (гэрлэх, жирэмслэх, сургуулиа хаях, хуучин нөхдөөсөө холбоо таслах ...гм)	0	1
10.	Өсөж том болохоос айх, гэр бүлийнхнээсээ илүү их анхаарал халамж шаардах	0	1
Нийт оноо			

G3.1 Тайлбар ба үнэлгээний үр дүн: Оноог доош нэмж, нийт оноог гаргана.

Нийт оноо	Авах арга хэмжээ
1-3	Анхаарал тавих, амраах, 7 хоногийн дараа дахин үнэлэх
4 - 6	Тусламж хэрэгтэй, сэтгэл зүйч болон сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага, мэргэжилтнээс тусламж авах
7 - 10	Яаралтай тусламж хэрэгтэй, сэтгэл зүйч болон сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага, мэргэжилтнээс нэн даруй тусламж авах, цаашдын оношилгоо эмчилгээнд анхаарах

ЖИЧ: Энэ илрүүлэг нь янз бүрийн насны хүүхэд хүчирхийлэлд өртсөний дараах бие болон сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг нь үнэлэх товч үнэлгээ бөгөөд энэ үнэлгээний үр дүн эмнэл зүйн оношинд нөлөөлөхгүй байж болно.

G.4 Хүүхэд, өсвөр үеийнхний илрүүлгийн асуумж – Сэтгэл зүйн гэмтэл үүсгэх үйл явдлын улмаас хүүхдэд учрах хор нөлөө / CRIES - Children's Impact of Event Scale /

Амьдралд нь стресстэй үйл явдал тохиолдсоны дараа үед доорх жагсаалтаар үнэлгээ хийнэ. Сүүлийн 2 долоо хоногийн хугацаанд аль хэр олон давтамжтай тохиолдож буйгаар нь хариултаа сонгоорой, зөв буруу хариулт гэж байхгүй бөгөөд яг өөрийнхөө нөхцөл байдлаар л хариулаарай.

Сүүлийн 2 долоо хоногт

4-р хүснэгт

д/д	Асуумж	үгүй	ховорхон	хааяа	дандаа
1.	Энэ тухай дурсаа ч үгүй байхад хар бодогдоод байна уу?	0	1	3	5
2.	Чи үүнийг ой санамжаасаа бүр авч хаяхаар оролддог уу?	0	1	3	5
3.	Анхаарал төвлөрөхөд хэцүү болсон уу?	0	1	3	5
4.	Энэ тухай мэдрэмж үе үе хүчтэй давлагаалан орж ирдэг үү? (нөмрөн авдаг уу?)	0	1	3	5
5.	Энэ явдал тохиолдсоны дараа илүү амархан цочиж, илүү их бухимдаж байна уу?	0	1	3	5
6.	Уг явдлыг санагдуулах газар орон, нөхцөл байдлаас зайлсхийж байна уу?	0	1	3	5
7.	Энэ талаар ярихгүй байхыг хичээдэг үү?	0	1	3	5
8.	Чи энэ талаар өөрийн оюун санаандаа дүрслэн боддог уу?	0	1	3	5
9.	Бусад юмс чамайг энэ талаар бодсоор байхад хүргээд байна уу?	0	1	3	5
10.	Чи энэ тухай бодохгүй байхыг хичээдэг үү?	0	1	3	5
11.	Чи амархан бухимдаж цухалдаж байна уу?	0	1	3	5
12.	Онцын хэрэгцээгүй үед сэрэмжлээд болгоомжлоод байна уу?	0	1	3	5
13.	Нойрны асуудал байна уу?	0	1	3	5
Нийт оноо					

Хийвэл зохих нас: сургуулийн нас (8-аас дээш настай, өөрөө уншиж чаддаг байх), тохирох хариултын дагуу оноог сонгоод доош нь нэмж хариуг гаргана. 0-65 хүртэл оноотой, босго оноо 30, оноо илүү дээшээ байх тусам Сэтгэл зүйн гэмтлийн дараах стрессийн эмгэг төдий их байна гэсэн үг.

Г.5 Хүүхэд, өсвөр үеийнхний илрүүлгийн асуумж – Сэтгэл гутралыг хүүхэд өөрөө үнэлэх нь (DSRSC – Depression Self Rating Scale for Children)

Чамд илүү сайн туслахын тулд бид өнгөрсөн 7 хоногийн турш чиний сэтгэл санаа, мэдрэмж ямар байсан талаар мэдэх хэрэгтэй байна. Энд зөв, буруу хариулт гэж байхгүй бөгөөд өөрийн нөхцөл байдалд хамгийн дөхөх хариултаа сонгоно уу.

5-р хүснэгт

д/д	Хариулт	Дандаа	Заримдаа	Ердөө ч үгүй
1.	Би урд нь ямар байсан шигээ урагшаа тэмүүлж байхыг хичээж байна			
2.	Би сайн унтдаг			
3.	Би яг уйлах нээ гэмээр болдог			
4.	Би гадаа тоглох дуртай			
5.	Би ямар 1 юмнаас зугтаад байгаа юм шиг санагддаг			
6.	Миний гэдэс өвддөг			

MNS 7065:2025

7.	Би их энергитэй			
8.	Би хоолондоо дуртай			
9.	Би өөрийнхөө төлөө бат бөх зогсож чадна			
10.	Амьдрал утгагүй гэж би боддог			
11.	Би өөрийгөө хийж байгаа зүйлдээ сайн (чадварлаг) гэж боддог			
12.	Би урд нь хийж байгаа зүйлдээ сэтгэл хангалуун байсан шигээ одоо ч сэтгэл хангалуун байдаг			
13.	Би гэр бүлийнхэнтэйгээ ярилцах дуртай			
14.	Би муухай зүүд зүүдэлдэг			
15.	Би их ганцаарддаг			
16.	Миний сэтгэл амархан сэргэдэг			
17.	Би их уйтгартай байдаг, арайхийж тэсэж байгаа юм шиг санагддаг			
18.	Би их уйддаг			
Нийт оноо				

Хүүхэд өөрийгөө үнэлэх энэ үнэлгээ 8–13 насны хүүхдэд зориулагдсан (зарим судлаач нар 8 – 16 насанд тохиромжтой гэж үздэг) 18 асуулттай, ердөө ч үгүй – 0, заримдаа – 1, дандаа - 2 гэж тооцно. 1, 2, 4, 7, 8, 9, 11, 13, 16-р асуултууд урвуу оноотой, үүнд ердөө ч үгүй – 2, заримдаа – 1, дандаа – 0 гэж тооцно. Доош нэмж нийлбэр оноог гаргана, босго оноо 15. Өндөр оноо сэтгэл гутралыг илтгэнэ, оноо өндөрсөх тусам сэтгэл гутрал төдий чинээ гүнзгий гэсэн үг.

G.6 Хүүхэд, өсвөр үеийнхний илрүүлэг асуумж – хүүхдийн сэтгэл түгшилттэй холбоотой эмгэгийг хүүхэд өөрөө үнэлэх (SCARED - Screen for Child Anxiety Related Disorders)

9-18 насныханд тохиромжтой, сүүлийн 3 сарын туршид өөрт илэрч байсан байдлаа бодож асуултад хариулна уу? 0 – худал, хэзээ ч үгүй 1 – зарим талаар байж болох л юм, заримдаа үнэн, 2 – яг үнэн, үргэлж ийм. Энд зөв буруу хариулт гэж үгүй, яг өөрийн байдлаа л бодож хариулаарай.

6-р хүснэгт

1.	Айж самгардсан үедээ амьсгалахад хэцүү болдог	0	1	2
2.	Сургуульдаа явахаар толгой өвдөөд байдаг	0	1	2
3.	Сайн мэдэхгүй хүмүүстэй хамт байх дургүй	0	1	2
4.	Гэрээсээ өөр газар хонохоор би айдаг	0	1	2
5.	Бусад хүмүүс надад дуртай байх вий гэж би санаа зовдог	0	1	2
6.	Би яг үхэх нь гэж айдаг	0	1	2
7.	Би бухимддаг	0	1	2
8.	Ээжийгээ юм уу аавыгаа хаа явсан газар нь дагадаг	0	1	2
9.	Хүмүүс намайг: чи бухимдсан харагдаж байна гэдэг	0	1	2
10.	Сайн мэдэхгүй хүмүүстэй хамт байхаар би бухимдаж эхэлдэг	0	1	2
11.	Сургууль дээр ходоод өвддөг	0	1	2
12.	Айсан үед би яг галзуурах гэж байгаа юм шиг санагддаг	0	1	2
13.	Ганцаараа унтахаар санаа зовнидог	0	1	2
14.	Бусад хүүхдүүд шиг “сайн” байх юм сан гэж санаа зовдог	0	1	2
15.	Айсан үед юмс бодит биш юм шиг санагддаг	0	1	2
16.	Ээж аавд минь муу юм тохиолдож байна гэж хар дарж зүүдэлдэг	0	1	2
17.	Сургуульдаа явахаас санаа зовдог	0	1	2
18.	Айсан үед зүрх түргэн түргэн цохилдог	0	1	2
19.	Би салгалдаг болсон	0	1	2
20.	Надад муу юм тохиолдож байна гэж хар дарж зүүдэлдэг	0	1	2
21.	Юмс надад чиглэн ажиллаад байна гэж санаа зовдог	0	1	2
22.	Би айсан үедээ их хөлөрдөг	0	1	2

23.	Би ер нь санаа зовогч	0	1	2
24.	Шалтгаангүйгээр маш их айдаг	0	1	2
25.	Би гэртээ ганцаараа байхаас айдаг	0	1	2
26.	Сайн мэдэхгүй хүмүүстэй ярилцах хэцүү байдаг	0	1	2
27.	Айсан үед миний амьсгал боогддог	0	1	2
28.	Хүмүүс намайг хэт их санаа зовох юм гэдэг	0	1	2
29.	Би гэр бүлийнхнээсээ хол байх дургүй	0	1	2
30.	Сэтгэл түгшилт юм уу сандрах дайрлагад өртөх вий гэж айдаг	0	1	2
31.	Эцэг эхэд минь муу юм тохиолдож магад гэж сэтгэл зовдог	0	1	2
32.	Сайн мэдэхгүй хүмүүстэй хамт байхаар ичээд байдаг	0	1	2
33.	Ирээдүйд юу болох бол гэж санаа зовдог	0	1	2
34.	Айсан үед яг бөөлжих гэж байгаа юм шиг санагддаг	0	1	2
35.	Би юмыг аль хэр сайн хийж байгаа бол гэж санаа зовдог	0	1	2
36.	Сургуульдаа явахаас айдаг	0	1	2
37.	Аль хэдийн болоод өнгөрсөн юманд ч санаа зовоод байдаг	0	1	2
38.	Айсан үед толгой эргэдэг	0	1	2
39.	Би бусад хүүхдүүд болон том хүмүүстэй байхаар бухимддаг бөгөөд, тэд нар намайг хараад байх юм бол ямар нэг юм (жишээ нь: чангаар юм унших, ярих, тоглох, спорт хийх ...гм) хийх юм шиг санагддаг	0	1	2
40.	Үдэшлэг бүжиг гэх мэт танихгүй хүмүүстэй хамт байх газар очихоор би бухимддаг	0	1	2
41.	Би ичимхий	0	1	2

Үнэлгээний үр дүн: 41 асуулттай, 0 – ердөө ч үгүй, 1 – заримдаа, 2 – дандаа, нийт оноо ≥ 23 бол сэтгэл түгшилт байна гэж үзнэ, оноо хэдий чинээ өндөр байна сэтгэл түгшилт төдий чинээ их байна.

Н хавсралт (норматив)

Амиа хорлох оролдлогыг илрүүлэх богино хэмжээний сорил

Өнгөрсөн сард чи:		Тийм	Үгүй	Оноо
C1	Сэтгэл зүйн хямдралд орсон уу? Үгүй бол C2 бөглөнө уу, тийм бол C1a бөглөнө уу			
C1a	Өөрийгөө егүүтгэх төлөвлөж байсан уу? Үгүй бол C2 бөглөнө уу, тийм бол C1b бөглөнө уу			
C1b	Сэтгэлийн хямралаас болж үхсэн нь дээр гэж санаж байсан уу?			
C2	Та үхсэн нь дээр гэж боддог байсан, эсвэл үхэхийг хүсэж байсан уу?			1
C3	Өөрийгөө егүүтгэх, хор учруулах эсвэл гэмтээхийг хүсэж байсан уу?			2
C4	Амиа хорлох тухай бодож байсан уу?			6

Тийм бол ямар давтамжтай, хэр хүчтэй энэ тухай бодож байсан бэ?

Давтамж	Хүч	Энэ хөтөлбөрт байгаа үед энэ үйл ажиллагааг хяналтад байлгаж чадах уу? Үгүй гэж хариулсан тохиолдолд 8 оноо авна			
Хаяа нэг <input type="checkbox"/>	Бага <input type="checkbox"/>				
Ойр ойрхон <input type="checkbox"/>	Дунд <input type="checkbox"/>				
Байнга <input type="checkbox"/>	Их <input type="checkbox"/>				
			Тийм	Үгүй	8

C5	Амиа хорлох төлөвлөгөө байна уу?			8
C6	Үхэхийн тулд амиа хорлох аргыг сонгож байсан уу?			9
C7	Өөрийгөө егүүтгэхгүй мөртөө өөртөө гэмтэл учруулж байсан уу?			4
C8	Амиа хорлох оролдлого хийж байсан уу? Амьд үлдэж магадгүй гэсэн бодолтой <input type="checkbox"/> Үхнэ гэсэн бодолтой			10
Чи өөрийнхөө өнгөрсөн амьдралд:				
C9	Амиа хорлох оролдлого хийж байсан уу			4

Нэг удаа “Тийм” гэж хариулсан тохиолдолд	Үгүй Тийм Амиа хорлох эрсдэл 1-8 оноо Бага 9-16 оноо Дунд 17 болон түүнээс дээш Их
“Тийм” гэж C1-C9 асуултад хариулсан үедээ	
Амиа хорлолттой холбоотой өөр мэдээллийг бичиж болно	

Ном зүй

- Хүүхэд хамгааллын тухай хууль
 Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль
 Хүүхдийн эрхийн тухай хууль
 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
 Гэр бүлийн тухай хууль
 Хувь хүний нууцын тухай хууль
 Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ), 1948
 Хүүхдийн эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ)-ын конвенц (ХЭК), 1990
 Эрүүл мэндийн сайд, соёл шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Үлгэрчилсэн загвар, жагсаалт батлах тухай” А/494, А/761
 Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зураглал батлах тухай” А/779 дугаар тушаал,
 Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн “Амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх заавар батлах тухай” А/149 дугаар тушаал,
 Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн “Хүчирхийлэлд өртсөн хүүхэд өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар батлах тухай” А/151 дугаар тушаал
 Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм
 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм
 Нийгмийн ажилтны ёс зүйн дүрэм
 О.Мягмар, “Сэтгэл заслын зөвлөгөөний арга зүй” 2009 он
 С.Бямбасүрэн, “Сэтгэцийн эрүүл мэнд” сурах бичиг 2010 он
 О.Мягмар, “Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд” 2012 он
 В.Баярмаа ба бусад “Хүчирхийллийн хохирогч ба үйлдэгчдэд үзүүлэх сэтгэл зүйн тусламж үйлчилгээ” эмнэл зүйн гарын авлага 2019 он
 А.Хонгорзул, Г.Түвшинжаргал, П.Энхчимэг “Сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч/ даван туулагч төвтэй арга зүй” Модуль-9, 2023 он
 З.Хишигсүрэн, Д.Оюунсүрэн “Жендерт суурилсан хүчирхийллийн хохирогч/даван туулагсдад үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ” Модуль-11, 2023 он
 Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (WHO), Нэгдсэн үндэстний хүн амын сан (UNFPA), Дүрвэгч хариуцсан Нэгдсэн үндэстний дээд түвшний төлөөлөгч (UNHCR). “Бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нарт зориулсан эмнэл зүйн удирдамж: Хүний эрхийг хангах хүрээнд ашиглах протокол”; 2020. Licence: CC BY-NC-SA 3.0 IGO.
 Сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэц нийгмийн тусламж үйлчилгээний багц (MHPSS) © IASC, 2022.
<https://www.unicef.org/media/155226/file/CCS%20Guidelines%20Final%20.pdf>
https://www.cdc.gov/healthyyouth/mental-health-action-guide/pdf/DASH_MH_Action_Guide_508.pdf
<https://applications.emro.who.int/docs/9789290225652-eng.pdf>

